



**“ЦЕМЕНТ ШОХОЙ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 07 сарын 28 өдөр

Дугаар A/150

Хөтөл

Цалин хөлсний журам
батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, “Цалингийн жишиг батлах тухай” Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 13 дугаар тогтоол, Компанийн дүрмийн 8.1, 8.9.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус компанийн “Цалин хөлсний журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү тушаалыг 2022 оны 07 дугаар сараас эхлэн мөрдөж ажиллахыг Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн даргын үүргийг түр гүйцэтгэгч /Б.Нямбаяр/, Санхүү, тайлан бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр гүйцэтгэгч /А.Сосорбурам/ нарт зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, хүний нөөцийн газрын даргын үүргийг түр гүйцэтгэгч /А.Галбаатар/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Л.НАРАНБААТАР



Гүйцэтгэх захирлын 2022 оны
07 дугаар сарын 28 ны өдрийн
А/150 дугаар тушаалын хавсралт



**“ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ЦАЛИН ХӨЛСНИЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Журмын зорилго

Ажил албан тушаалын онцлогийг харгалзан зах зээлд өрсөлдөхүйц цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, хөнгөлөлт, урамшуулал олгох, ХАБЭА-н зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цалин урамшууллын өнөөчтой системийг нэвтрүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2 Журмын хамрах хүрээ “Цемент Шохой” ТӨХК-ийн хэмжээнд дагаж мөрдөнө.

Хоёр. Журмын нэр томъёо

Журамд хэрэглэх нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

- 2.1. **Компани** гэж: “Цемент Шохой” ТӨХК-ийг ойлгоно. (Цаашид компани гэх)
- 2.2. **YAMAT -08-** мэргэжлийн индекс, код нь-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 02-р сарын 10-ны өдрийн №16 тоот тушаалаар батлагдсан Үндэсний ажил мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолтын дагуу компанид мөрдөгдөж буй бүх ажлын байрыг тодорхойлолт юм.(Цаашид YAMAT-08 гэх)
- 2.3. **Ажилтан** гэж: Компанийн бүх ажилтныг
- 2.4. **ИТА** гэж: Инженер техникийн ажилтныг
- 2.5. **Нэгж** гэж: компанийн газар, хэлтэс, үйлдвэр, албыг
- 2.6. **Нэгжийн дарга** гэж: компанийн газар, хэлтэс, үйлдвэр, албаны даргыг
- 2.7. **Интервалт цалин** гэж: Хөдөлмөрийн бүтээмжээс хамаарсан цалин
- 2.8. **Цалин хөлс** нь:
 1. Үндсэн цалин (үндсэн болон цагийн тарифт цалин)
 2. Нэмэгдэл хөлс
 3. Нэмэгдэл
 4. Ээлжийн амралтын цалин
 5. ХАБЭА-н урамшуулал
 6. Бүтээлийн урамшуулал
 7. Өртөгт суурилсан урамшуулал гэсэн үндсэн бүтэцтэй байна.

Гурав. Үндсэн цалин


3.1 Үндсэн зүйл

- 3.1.1 Үндсэн цалин нь ажил, албан тушаалын зорилго, үндсэн үүрэг, тавигдах шаардлага, хөдөлмөрийн нөхцөл, ажилтны мэргэжил, туршлага, ур чадварын түвшин, гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжээс хамааран харилцан адилгүй байна.

- 3.1.2 Нийт ажилтнуудын ажилласан цагийн балансыг цаг бүртгэлийн программчилсан бүртгэлийг үндэслэн тооцно. Цаг бүртгэлтэй холбогдон гарах аливаа асуудал маргааныг “Цаг бүртгэлийн журам”-ыг баримтлан шийдвэрлэнэ. Цагийн бүртгэлд холбогдох нэгжийн дарга, ИТА нар хяналт тавьж баталгаажуулна.
- 3.1.3 Компанийн хэмжээнд ажлын байрны үнэлгээтэй холбогдсон асуудлыг Гүйцэтгэх захирлын тушаалаар комисс томилогдон боловсруулна.
- 3.2. Ажилтнуудын сарын үндсэн цалин
- 3.2.1 Ажилтнуудын үндсэн цалинг YAMAT-08-ын дагуу 5 бүлэг болгон ангилан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо, эсвэл ТУЗ-өөс эцэслэн баталсан цалинг мөрдөнө. (хавсралт №1-1, №1-2)
- 3.2.2 Ажилтнуудын үндсэн цалинг тогтоохдоо цалин хөлсний журмын хавсралт №1-1, 1-2-т заасан хэмжээнд тохируулан тухайн нэгжийн даргын саналаар хариуцсан дарга баталгаажуулан Гүйцэтгэх захирлын тушаал гаргуулж мөрдөнө.
- 3.2.3 Компанийн интервалт цалинтай ажилтнуудын цалинг ажлын хариуцлага болон хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр (KPI) тооцно. Үндсэн цалин нь тогтмол(70%) болон хувьсах (30%) цалингаас бүрдэнэ. Хувьсах цалинг хавсралт №6-д заасан аргачлалын дагуу KPI тооцож олгоно. Ажилтнуудын хувьсах цалингийн хэмжээг холбогдох нэгжийн дарга нар сар бүр үнэлж тухайн сарын 25 өдрийн дотор Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэст хүргүүлнэ.
- 3.2.4 Ажлын гүйцэтгэлийн урамшууллыг тухайн сардаа өгөгдсөн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлсэн байхын зэрэгцээ сахилга баттай, хариуцлагатай, өндөр үр бүтээмжтэй аль эсвэл өртөг зардал бууруулах гэх мэт шинэ санал санаачлага гарган хэрэгжүүлсэн бол тухайн нэгжийн дарга дүгнэлт гарган үндсэн цалингийн 10 хүртэлх хувиар олгож болно.
- 3.2.5 Гүйцэтгэх захирал тухайн сард өгөгдсөн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлж, онцгой амжилт гаргасан ажилтанд нэг сарын үндсэн цалин хүртэлх хэмжээний урамшуулалт цалин олгоно.
- 3.2.6 Гүйцэтгэх захирлын тушаалыг үндэслэн тооцон олгож буй үндсэн ажлаас бусад ажлын хөлс нь цалинд тооцогдох ажлын цагтай давхардахгүй байх ба тухайн хийсэн ажлын хөлс нь батлагдсан үнэлгээ, баримт бүрдүүлэлт, ажлын хуваарийн дагуу явагдаж цалингийн тооцоонд “ажлын хөлс” нэрээр тусгагдана.
- 3.3. Мэргэжилтэй ажилтнуудын цалин хөлс
- 3.3.1 Мэргэжлийн ажилтнууд ажлын байрны II-YI зэрэглэлтэй байна.
- 3.3.2 Ажилтны сарын цалинг тооцохдоо ажилласан цагийг мэргэжлийн тариф сүлжлээр тогтоосон (хавсралт №02) тухайн ажлын байрны зэрэглэлд харгалзах цагийн цалингийн тарифаар үржүүлж гаргана.
- 3.3.3 Засварчин, гагнуурчин, цахилгаанчин, сантехникч, нарийн хэмжүүрийн засварчдыг тухайн ажилтны эзэмшсэн мэргэжлийн зэргээр, Технологийн ажилтнууд Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулсан зэрэглэлээр цалинжуулна. (хавсралт №1-2). Тухайн ажлын байрны шаардлагад нийцсэн ажилтан ажиллуулахыг нэгжийн дарга бүрэн хариуцна.
- 3.3.4 Дээд мэргэжлээр төгсөж ирсэн ажилтан өөрийн мэргэжлийн дагуу бага зэрэглэлтэй ажлын байранд ажиллаж байгаа тохиолдолд холбогдох нэгжийн даргын шалган тогтоосны дагуу Гүйцэтгэх захирлын тушаалаар зэргийг тогтоон ажиллуулж болно.




- 3.4 Хийснээр цалинждаг ажилтны цалин хөлс
- 3.4.1 Хийснээр цалинждаг ажилтны ажлын байрны жагсаалтыг энэхүү журмын хавсралтаар баталж мөрдөнө. (Хавсралт №3)
- 3.4.2 Хийснээр цалинждаг ажилтнуудад бүтээлийн нормыг үндэслэн тогтоосон хөдөлмөрийн үнэлгээг (Хавсралт № 3-1,3-2) мөрдөнө. Энэхүү үнэлгээг зөвхөн хийсэн ажлын тоо хэмжээгээр хөдөлмөрийн хөлсийг тооцоход ашиглах бөгөөд нэмэгдэл цалинг тухайн ажилтны үндсэн цалингаас тооцно. Эдгээр ажилтнуудыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засварын үед цагийн тарифт цалингийн IV-р зэргээр цалинжуулна.
- 3.5 Сул зогсолтын үеийн цалин
- 3.5.1 Үйлдвэрлэлийн зохион байгуулалтаас шалтгаалсан /сэлбэг материалгүй, цахилгааны хязгаарлалт, вагон хангамж байхгүй гэх мэт/ үйлдвэрийн хэмжээний зогсолт, тоног төхөөрөмжийн эвдрэлийг сул зогсолт гэж тооцно. (Ажлын нэг ба түүнээс дээш өдөр үйлдвэр зогссон нөхцөлд сул зогсолтод тооцно)
- 3.5.2 Хийснээр цалинждаг ажилтнуудыг сул зогсолтын үед өөр ажилд шилжүүлэхгүйгээр ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй ажлаар түр хангавал цагийн тарифт цалингийн IV-р зэргээр цалинжуулна.
- 3.5.3 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сул зогсолтын үед тухайн нэгжийн дарга нь илүү цаг гаргахгүйгээр хөдөлмөр зохион байгуулалтыг оновчтой хийж, Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулна.
- 3.5.4 Сул зогсолтын үед ажилтанд түүний үндсэн цалингийн 60-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний олговор олгох бөгөөд олговрын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байж болохгүй.
- 3.5.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл буюу бүх нийтийг хамарсан цар тахал, гамшгийн үед Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлана. /сул зогсолтын хугацаанд түүнийг өөр ажилд шилжүүлэх боломжгүй тохиолдолд/
- 3.5.6 Ажилтныг дуудан ажиллуулах тохиолдолд холбогдох нэгжийн захиалгын дагуу Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулна. (Анхны тушаалд ороогүй тохиолдолд)
- 3.5.7 Чөлөөний хугацаанд ажилтан дуудагдан ажилласан бол Инженер /шуурхай удирдлага/-т тухай бүрд нь цагаа бүртгүүлж холбогдох нэгжийн даргаар баталгаажуулна.
- 3.5.8 Дуудагдан ажилласан тохиолдолд ажилласан цагийг тухайн ажилтны зэргээр цалинг тооцох, нөхөн олговрыг чөлөөнд суувал зохих цагаас ажилласан цагийг ногдуулан хасаж тооцно.
- 3.5.9 Захиргааны санаачилгаар үндсэн ажлаас чөлөөлөгдөн сургалтад хамрагдсан ажилтнуудын цалинг үндсэн цалингийн 80 хувиар тооцон олгоно.
- 3.5.10 Дотоод журмын дагуу гүйцэтгэх захирлын тушаалаар олговор, тэтгэмж бүхий чөлөө олгосон ажилтнуудад үндсэн цалингийн 80 хувиар тооцон цалинг олгоно.
- 3.6 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засварын үеийн цалин
- 3.6.1 Төлөвлөгөөт засвар гэж. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үйлдвэрлэлийг зогсоож бүрэн засвар хийх, техник технологийн шинэчлэл, техникийн ашиглалтын хугацааг уртасгах, техникийн бүрэн задаргаа хийх зэрэг ажлуудыг хэлнэ.



- 3.6.2 Төлөвлөгөөт их засварын үед ажиллах ажилтнуудад Гүйцэтгэх захирлын тушаалаар цаг зэргийн тарифт цалин тооцож олгоно. Мөн ажлын үр дүнг харгалцан үндсэн цалингийн 10-30 хувийн урамшууллыг Гүйцэтгэх захирлын тушаалаар олгож болно.
- 3.6.3 Төлөвлөгөөт бус засвар гэж: Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад тоног төхөөрөмжийг шинээр солих, үйлдвэрлэлийн явцад гарсан тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэлийг засварлах үеийг хэлнэ.
- 3.6.4 Компаний зохион байгуулалтын нэгжид төлөвлөгөөт бус засварын ажлын үед тухайн нэгжид ажиллаж буй засварчид үндсэн цалингийн 80 хувиар цалинжина.
- 3.6.5 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засварын үед сул зогссон технологийн ажилтнуудыг үндсэн цалингийн 60 хувиар тооцож цалинжуулна. /Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засварын үед ажилтныг өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно./
- 3.7 Хөдөлмөрийн хугацаатай гэрээ байгуулж ажиллаж байгаа ажилтнуудын цалин
- 3.7.1 Компанид шинээр ажилд орж байгаа ажилтныг дагалдан болон туршилтын хугацаагаар ажиллуулна.
- 3.7.2 Дагалдан болон туршилтын хугацаа нь 1-3 хүртэл сарын хугацаатай байх ба тухайн ажилтны туршилтын хугацааг уг ажилтны мэргэжлийн түвшин, ур чадвар, дадлага туршлагыг харгалзан холбогдох нэгжийн дарга нарын тодорхойлолтоор Гүйцэтгэх захирлын тушаалаар тогтооно.
- 3.7.3 Туршилтын хугацаагаар ажиллаж байгаа бол тухайн ажлын байрны үндсэн цалингаар, дагалдан ажиллаж байгаа бол тухайн ажлын байрны үндсэн цалингийн 80 хувиар цалинжина.
- 3.8 Ажиллагсдад тогтоосон хугацаанаас өмнө цалин хөлсийг урьдчилан олгохгүй.

Дөрөв . Нэмэгдэл хөлс, нэмэгдэл


- 4.1 Ажилтанд үндсэн цалин дээр дараах нэмэгдлүүдийг тооцож олгоно.
- 4.1.1 Хөдөлмөрийн нөхцлийн нэмэгдэл
- 4.1.2 Удаан жилийн нэмэгдэл
- 4.1.3 Бичиг хэргийн ажилтны нэмэгдэл
- 4.2 Ажилтанд үндсэн цалин дээр дараах нэмэгдэл хөлсийг тооцож олгоно.
- 4.2.1 Орлон ажилласны нэмэгдэл хөлс
- 4.2.2 Хавсран ажилласны нэмэгдэл хөлс
- 4.2.3 Баярын өдрүүдийн нэмэгдэл хөлс
- 4.2.4 Шөнийн нэмэгдэл хөлс
- 4.2.5 Ажил, хослон гүйцэтгэсний нэмэгдэл хөлс
- 4.2.6 Илүү цагийн нэмэгдэл хөлс
- 4.3 Хөдөлмөрийн нөхцлийн нэмэгдэл
- 4.3.1 Үйлдвэрийн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг хууль тогтоомжид нийцүүлэн ХАБЭАБОХэлтэс Монгол Улсын Стандартын дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэж, ажлын байрны нөхцлийг тодорхойлох ба нэмэгдэл олгох хувь хэмжээг 3 ангилж тарифын дагуу Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс тооцон олгоно. /Хавсралт №04/



- 4.3.2 Сантехникийн засварчид, бохирын үйлчлэгч нарын бохирын нэмэгдэл цалингийн нөхцөлийн нэмэгдэл гэж тооцно.
- 4.3.3 Ажлын байрны нөхцөлийг сайжруулахын тулд эрүүл орчин бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг жил бүрийн бизнес төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.
- 4.4 Удаан жил ажилласны нэмэгдэл
- 4.4.1 Ажилтанд ажилласан жилийн нэмэгдэл хөлсийг тус компанид тасралтгүй ажилласан жилээс хамааруулан жилд нэг удаа тухайн жилийн дундаж цалин хөлснөөс тооцон /дундаж цалин хөлсний тооцоо нь ээлжийн амралтын цалингийн тооцоотой адил байна/ ээлжийн амралтын цалин дээр нэмж олгоно. Ажилласан жил тасарсан тохиолдолд сүүлийн ажилд орсон хугацаанаас ажилласан жилийг тооцно.
- 4.4.2 Удаан жил ажилласны нэмэгдлийг дараах хувь хэмжээгээр тооцон олгоно.

д/д	Ажилласан жил	Нэмэгдэл олгох хувь
1	5 жил 1 сар -8 жил хүртэл	50%
2	8 жил 1 сараас-15 жил хүртэл	75%
3	15 жил 1 сараас дээш	100%

- 4.5 Орлон ба хавсран ажилласны нэмэгдэл хөлс
- 4.5.1 Орлон ба хавсран ажилласны нэмэгдэл хөлсийг Гүйцэтгэх захирлын тушаалыг үндэслэн олгоно.
- 4.5.2 Өөрийн ажил үүргээс гадна өөр ажил орлон ажиллаж байгаа бол аль өндөр тарифтай албан тушаалын цалингаар цалинжина.
- 4.5.3 Эзгүй байгаа ажилтны ажил үүргийг Гүйцэтгэх захирлын тушаалаар хавсран гүйцэтгэж байгаа ажлын байрны үндсэн цалингийн 30 хувиар нэмэгдэл хөлс олгоно.
- 4.5.4 Засварчин, цахилгаанчин, сантехникч нарын ажлыг хавсран гүйцэтгэж буй ажилтанд үндсэн цалингийн 30 хувиар нэмэгдэл хөлс олгогдоно.
- 4.5.5 Мэргэжил орлон ба хавсран ажиллах хугацаа 45 хоногоос хэтрэхгүй. Түүнээс дээш орлон, хавсран ажиллах тохиолдолд тухайн орон тоог Хүний нөөцийн хэлтэс хянан шийдвэрлэнэ.
- 4.6 Баярын нэмэгдэл хөлс
- 4.5.1 Ажил олгогч ажилтантай тохиролцсоноор нийтээр амрах баярын өдөр ажиллуулж болно. Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол ажилласан цагийг үндсэн цалингийн тарифыг 2 дахин нэмэгдүүлж тооцож олгоно.
- 4.5.2 Ээлжийн графикаар тасралтгүй ажиллахаар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтны ээлж амралтын өдөр таарсан тохиолдолд баярын нэмэгдэл олгохгүй.
- 4.5.3 Баярын өдрүүдэд Гүйцэтгэх захирлын тушаалаар хариуцлагатай эргүүл, жижүүрээр томилогдон ажиллах ажилтан график амралтын өдрүүдэд таарвал Инженер /шуурхай удирдлага/-ийн бүртгэлийг үндэслэн Ерөнхий инженер бөгөөд үйлдвэрлэл технологийн газрын дарга баталсны үндсэн дээр



бүтээлтэй ажилласан цагт ногдуулан баярын нэмэгдлээр тооцон үндсэн цалингийн тарифыг 2 дахин нэмэгдүүлж олгоно.

4.7 Шөнийн нэмэгдэл хөлс

4.7.1 Хөдөлмөрийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дүгээр хэсэгт заасны дагуу орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацааг шөнийн цагт тооцно.

4.7.2 Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно.

4.7.3 Шөнө ажилласан цаг тутамд 1000 төгрөгөөр тооцож нэмэгдлийг олгоно.

4.8 Ажил, албан тушаал хослон ажилласны нэмэгдэл хөлс

4.8.1 Ажилтнаар эзэмшсэн мэргэжлийн дагуу өөр ажил хослон гүйцэтгүүлж болох ба энэ тохиолдолд ажилтны ажлын байрны тодорхойлолтод нэмэгдлээр тусгасан байна.

4.8.2 Ажил, албан тушаал хослон гүйцэтгэх ажилтан нь дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Мэргэжлийн үнэмлэх

- Ажил үүрэг хослон гүйцэтгэхийг хүссэн хувийн өргөдөл

4.8.3 Хос мэргэжлээр ажиллах цаг нь нийт ажлын цагийн 20 хувиас хэтрэхгүй байна.

4.8.4 Хос мэргэжлээр ажилласан ажилтанд 2 дахь мэргэжлээр ажилласан цагаас шууд хамааралтайгаар үндсэн мэргэжлийн цалин дээр хос мэргэжлээр ажилласны нэмэгдлийг нэмж олгоно.

4.8.5 Хос мэргэжлээр ажилласан цагийн үнэлгээ нь үндсэн цалингийн III зэргийн тариф байна.

4.8.6 "Хос мэргэжлээр ажилласан тодорхойлолт" маягтын дагуу хос мэргэжлээр ажилласан ажилтны хийсэн ажил, цагийн бүртгэлийг Тооцоологч эдийн засагч хянаж, нэгжийн дарга, Ерөнхий инженер бөгөөд үйлдвэрлэл технологийн газрын дарга баталсны дараа нэмэгдлийг тооцож, цалингийн баримтад хавсаргана.

4.9 Илүү цагийн нэмэгдэл хөлс

4.9.1 Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.4 дэх заалтад заасны дагуу илүү цагаар ажиллуулна.

4.9.2 Оффисын ажилтны илүү цагийн дээд хязгаар нь нэг сард 8 цагаас илүүгүй байх ба илүү цагийн нэмэгдэл хөлс олгоогүй тохиолдолд нөхөн амраана.

4.9.3 Ажлын зайлшгүй шаардлагаар илүү цагаар ажиллах тохиолдолд холбогдох Газрын даргаас зөвшөөрөл авч Инженер /шуурхай удирдлага/-т бүртгүүлж баталгаажуулна.

4.9.4 Илүү цагийн нэмэгдэл хөлсийг "Илүү цагаар ажиллуулах журам"-ын дагуу тооцож олгоно.

4.9.5 Ажил, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан өдрийн болон долоо хоногийн ажлын цагийг баримтлах боломжгүй үед "Илүү цагаар ажиллуулах журам"-аар (Хавсралт №6) зохицуулна.

4.10 Бичиг хэргийн ажилтны нэмэгдэл

4.8.1 Гүйцэтгэх захирлын тушаалаар нэгжүүдийн бичиг хэргийн ажлыг хавсран гүйцэтгэсэн ажилтнуудад ажлын гүйцэтгэлийг үндэслэн тарифт цалингийн III-р зэргээс 15 хувийг тооцож, нэмэгдэл олгоно.



Тав . Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн зөрчилгүй ажилласны урамшуулал

- 5.1 Сарын урамшууллын хэмжээ-100,000 төгрөг байна.
- 5.2 Сарын урамшууллыг "Ажлын гүйцэтгэлээр хөдөлмөрийн аюулгүй байдлыг үнэлэх журам" –аар зохицуулна.
- 5.3 ХАБЭАБО-ны хэлтсээс тодорхойлсон дараах тохиолдолд урамшуулалыг хасна.

Үүнд:

- Үйлдвэрлэлийн орчинд ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглээгүй;
- Үйлдвэрлэлийн үйл явцад санаатай болон санаандгүй осол гаргасан;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм, стандарт, технологийн горимыг чанд мөрдөөгүй;
- Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд оруулах нөхцөл байдлыг бий болгосон;

Зургаа. Ээлжийн амралтын цалин

- 6.1 Ажилтны ээлжийн амралтын цалинг тооцоолон тухайн сарын цалин дээр олгоно.
- 6.2 Ажилтны ээлжийн амралтыг Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.
- 6.3 Ажилтны ээлжийн амралтын нэмэгдэл хоног, болон удаан жилийн нэмэгдлийг Хүний нөөцийн мэргэжилтэн тооцож Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулна.
- 6.4 Жирэмсний болон амаржсаны амралт авах, хүүхэд асрах чөлөөтэй болон бусад шалтгаануудын улмаас ажилтан удаан хугацаагаар эзгүй байх тохиолдолд ээлжийн амралтын тооцоог бүрэн хийж дуусгана.
- 6.5 Хэрэв шинээр ажилд орсон ажилтан болон ээлжийн амралтын цалин аваагүй ажилтан ажлаас гарч, компанитай байгуулсан хөдөлмөрийн гэрээ дуусах бол ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоог хийнэ.

Долоо. Бүтээлийн урамшуулалт цалин

- 7.1 Бүтээлийн урамшуулалт цалин гэж тухайн ажилтны бүтээлийн гүйцэтгэлийн тайланг үндэслэн олгох нэмэгдэл урамшуулалт цалинг хэлнэ.
- 7.2 Бүтээлийн урамшуулалт цалинг цех нэгжийн онцлогоос хамаарч /хавсралт № 5/ дагуу хувь хэмжээгээр тооцож олгоно.
- 7.3 II-VI зэрэгтэй ажилтанууд тухайн урамшуулалт хамрагдана.
- 7.4 Бүтээлийн урамшуулалт цалинг дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд 100% хасна. Үүнд:
1. 8 цагаас дээш ажил тасалсан;
 2. Эд хөрөнгийн болон сахилгын шийтгэл Гүйцэтгэх захирлын тушаалаар ногдуулсан;
 3. Холбогдох нэгжийн дарга нарын тодорхойлолтоор бүтээлийн урамшуулалт цалинг 100 хувь хүртэлх хэмжээгээр хасах эрхтэй.

Найм. Өртөгт суурилсан урамшуулалт цалин



- 8.1 Нэгж бүтээгдэхүүний өртгийг бууруулж, бүтээмж, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд холбогдох нэгжийн ажилтнуудтай Гүйцэтгэх захирал "Өртөгт суурилсан менежментийн үр дүнгийн гэрээ"-г байгуулна.
- 8.2 Компанийн тухайн жилийн эдийн засгийн зорилтот түвшний хүрээнд баталсан нэгж бүтээгдэхүүний өртгийг компанийн холбогдох нэгжүүдэд зорилтот дээд хязгаар болгон өгч, жилийн эцсийн гүйцэтгэлээр нэгж өртгийг уг зорилтот дээд хязгаараас бууруулсан тохиолдолд хэмнэсэн нийт зардлын 50 хүртэл хувиар урамшуулал тооцож дараах холбогдох нэгжийн ажилтнуудад албан тушаалын үүрэг, хариуцлагын түвшинээс хамааруулан "Өртөгт суурилсан менежментийн үр дүнгийн гэрээ"-нд заасны дагуу хуваарилна.
- Удирдах ажилтан
 - Мэргэжилтэн
 - ИТА
 - ТА
- 8.3 Ийнхүү хуваарилахдаа холбогдох нэгжүүдийн онцлогийг харгалзан, тухайн үйлдвэрлэлийн нэгжийн өртгийг илүү бууруулсан нэгжийн удирдлагуудад үр дүнгээс хамаарч хуваарилалт хийх шударга зарчим баримтлана.
- 8.4 Өртөгт суурилсан менежментийн урамшууллын сангийн дээд хэмжээ нь тухайн жилийн эдийн засгийн зорилтот түвшингээр батлагдсан цалингийн нийт сангийн 15%-иас ихгүй байна.

Ес . Үйлчилгээний ажилтнуудын
урамшуулал

- 9.1 Туслах болон үйлчилгээний ажилтнуудын үйлчилгээний урамшууллыг энэхүү журмын 7 дугаар хавсралтаар батлагдсан "Үйлчилгээний ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам"-ын ба Үнэлгээний хуудсаар дүгнэж сар бүр олгоно.
- 9.2 "Үйлчилгээний ажилтнуудын урамшуулалыг ажлын гүйцэтгэл болон үйлчилгээний чанараас хамааран дараах байдлаар тооцно. Үүнд:
- 70 хувиас дээш бол тухайн сарын үндсэн цалингийн 10%
 - 80 хувиас дээш бол тухайн сарын үндсэн цалингийн 15%
 - 90 хувиас дээш бол тухайн сарын үндсэн цалингийн 20%

Арав. Цалингийн нууцлал

- 10.1 Цалин хөлсний нууцлалыг дараах 2 шатанд хангаж ажиллана. Үүнд:
- 10.1.1 Шийдвэрийн шатанд
 - 10.1.2 Бүртгэлийн хяналтын шатанд
- 10.2 Шийдвэрийн шатанд нууцлалыг хангах
- 10.2.1 Компанийн ажилтнуудын үндсэн цалинг МАШ НУУЦ зэрэгтэйгээр гаргаж батална.
 - 10.2.2 Компанийн ажилтнуудын цалинг компанийн Гүйцэтгэх захирал, Захиргаа, удирдлага, хүний нөөцийн газрын дарга, Хүний нөөцийн хэлтсийн дарга, Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн, Хөдөлмөрийн эдийн засагч, Тооцоологч эдийн засагч, Цалин мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч нар танилцах эрхтэй байна.



- 10.2.3 Ажилтан цалин хөлстэй холбоотой мэдээллийг бусад этгээдэд санаатай буюу санамсаргүй байдлаар задруулах, задруулахыг завдах, дамжуулахыг хатуу хориглоно. Цалингийн тодорхойлолт хэвлэж, дугаар олгож, бүртгэж буй ажилтан цалингийн нууцыг чандлан хадгална.
- 10.2.4 Ажилтнууд өөрийн цалин хөлстэй холбоотой мэдээлэлтэй Цалин мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч, харьяа нэгжийн Тооцоологч эдийн засагч нартай шууд харилцаж танилцах бөгөөд бусад ажилтнуудаас энэ төрлийн мэдээллийг сонирхохгүй, мэдсэн тохиолдолд бусдад задруулахгүй, өөрийн цалин хөлсийг бусдад задруулахгүй байх, хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх үүрэгтэй.
- 10.2.5 Цалин хөлс, урамшуулал, тусгай ажил үүрэг гүйцэтгэсний нэмэгдлийн хувь хэмжээг нийтэд илээр зарлаж мэдэгдэхийг хориглоно.
- 10.2.6 Энэхүү журмын 10.2.2-т заасан ажилтнуудтай Хууль, эрх зүйн хэлтэс холбогдох журмын дагуу "Нууцын гэрээ"-г байгуулна.
- 10.3 Бүртгэлийн шатанд нууцлалыг хангах
- 10.3.1 Цалин мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч, Хөдөлмөрийн эдийн засагч, нэгжүүдийн Тооцоологч эдийн засагч нар нь ажилтны цалин, урамшууллыг бодох, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, орлогын албан татвар, цалингийн зээл зэрэг бүх төрлийн суутгалыг үнэн зөв гүйцэтгэж нууцлалыг ханган ажиллана.
- 10.3.2 Цалин мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч нь ажилтны цалинтай холбогдсон мэдээлэл бүхий тушаал, гүйлгээний баримт, файлийг нууцын шаардлагын дагуу ашиглаж, хадгалж, хамгаална.
- 10.3.3 Ажилтан нь ямарч тохиолдолд өөрийн цалингийн бодолт, суутгал, шимтгэлтэй холбогдсон мэдээллийг Цалин мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч, Хөдөлмөрийн эдийн засагч, нэгжүүдийн Тооцоологч эдийн засагч нараас шууд тодруулах эрхтэй.
- 10.3.4 Ажилтны цалингийн задаргааг Цалин мөнгөн хөрөнгийн нягтлан бодогчоос ажилтанд хувийн и-мэйл хаягаар хүргүүлнэ.
- 10.3.5 Ажилтанд цалингийн задаргааг цаасаар хэвлэж өгөхийг хориглоно.
- 10.3.6 Ажилтны цалингийн мэдээллийг өөр хүнд дамжуулах, мэдээллэхийг хатуу хориглоно.

Арван нэг. Үүрэг, хариуцлага, хяналт

- 11.1 Энэхүү журмын дагуу нэгжийн дарга нар хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, ажлын цаг ашиглалтыг нягтруулах, ажил үүргийн давхардал хийдлийг арилгах чиглэлээр тогтмол арга хэмжээ авах, шийдвэр гаргах, батлагдсан орон тооны хуваарийг чанд сахиж, хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.
- 11.2 Үйлдвэрлэлийн эдийн засагч нэгжүүдийн цалин бодох тарифыг тогтоосон шалгуур үзүүлэлтээр сар бүрийн "Түлш түүхий эдийн акт"-ыг үндэслэн "Үйлдвэрлэлт, цалингийн үзүүлэлт тогтоох акт"-г дараа сарын 26-ны дотор холбогдох комиссоор батлуулан Хөдөлмөрийн эдийн засагчид өгнө.
- 11.3 Нэгжүүдийн инженер техникийн ажилтнууд нь цагийн бүртгэлийг давхар үнэн зөв засваргүй бүртгэх, цаг бүртгэлийн программд мэдээллийг оруулах ба



- холбогдох баримт бичгийг цаг хугацаанд нь бүрдүүлж тухайн сарын 26-ны дотор тухайн нэгж хариуцсан Тооцоологч эдийн засагчид өгөх үүрэг хүлээнэ.
- 11.4 Нэгжүүдийн Тооцоологч эдийн засагч нар нь ажилтан нарын цалингийн анхан шатны баримт бичгийг хянах, цалин хөлсийг энэхүү журмын дагуу бодох, Хөдөлмөрийн эдийн засагчийн гаргасан хуваарийн дагуу цалин хөлсний програмд тухайн сарын 28-ны дотор үнэн зөв бүртгэж оруулах ажлыг хариуцна.
- 11.5 Хөдөлмөрийн эдийн засагч нь энэхүү журмын дагуу гарсан тушаал шийдвэрийн хүрээнд Захиргаа болон Аж ахуйн албаны ажилтнуудын цалин бодох, нэгжүүдийн Тооцоологч эдийн засагч нараас ирүүлсэн цалингийн анхан шатны баримтыг үндэслэн цалингийн бодолтыг програмтай тулган хянаж, тооцооллыг програмд бүртгэж оруулахаас өмнө шалгах, хүлээн авсан цалингийн баримтыг үдэх, архивлах, дотоод хяналт болон гадны хяналт шалгалтад цалингийн баримтыг шалгуулах үүрэгтэй.
- 11.6 Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга нь цалингийн бодолт, баримт бүрдэлтэд давхар хяналт тавина.
- 11.7 Цалингийн анхан шатны баримтыг засварлах, устгах, нуух, хуурамчаар үйлдэх зэрэг буруутай үйлдэл хийсэн ажилтан нарт дотоод журмын дагуу хариуцлага тооцно.
- 11.8 Энэхүү журамд тусгагдаагүй цалин хөлстэй холбоотой маргааныг холбогдох хууль, журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

--- 000 ---




"Цемент Шохой" ТӨХК-ийн албан тушаалын ангилал

№	Нэгжийн нэр	Албан тушаал	Мэргэжлийн ангилал	Үндсэн цалин	Дээд интервал
1	Удирдлага	Гүйцэтгэх захирал	У	9,500,000	9,500,000
2		Дотоод аудитор	А-М	7,000,000	7,000,000
3	Үйлдвэрлэл технологийн газрын дарга	Ерөнхий инженер бөгөөд Үйлдвэрлэл технологийн газрын дарга	У	8,000,000	8,000,000
4		Газрын дарга	У	6,000,000	8,000,000
5	Захиргаа удирдлага, хүний нөөцийн газар	Дотоод шийдвэрийн биелэлт, дотоод асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	А-М	2,487,800	2,985,360
6		Нарийн бичиг	ТА	1,727,600	2,073,120
7		Захирлын туслах	ТА	1,727,600	2,073,120
8		Архив, бичиг хэргийн ажилтан	ТА	1,727,600	2,073,120
9	Хүний нөөцийн хэлтэс	Хэлтсийн дарга	У	4,000,000	4,032,000
10		Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн	А-М	2,487,800	2,985,360
11		Хөдөлмөрийн харилцаа хариуцсан хуулийн мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
12		Хүний нөөцийн мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
13		Сургалт хөгжлийн мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
14		Нийгмийн ажилтан	М	2,392,600	2,871,120
15	Хууль, эрх зүйн хэлтэс	Хэлтсийн дарга	У	4,000,000	4,032,000
16		Бүтээгдэхүүн борлуулалтын гэрээ хариуцсан хуульч	М	2,392,600	2,871,120
17		Худалдан авах ажиллагаа, эрх зүйн маргаан хариуцсан хуульч	М	2,392,600	2,871,120
18	Техникийн бодлогын хэлтэс	Хэлтсийн дарга	У	4,000,000	4,032,000
19		Ахлах мэргэжилтэн /механик/	А-М	2,487,800	2,985,360
20		Ахлах мэргэжилтэн /эрчим зүй, автоматжуулалт/	А-М	2,487,800	2,985,360
21		Техник засварын мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
22		Төлөвлөлтийн инженер	М	2,392,600	2,871,120
23		Өргөн тээвэрлэх машин механизм хариуцсан	М	2,392,600	2,871,120
24		Эрчим хүч хэмнэлтийн мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
25		Цахилгаан хангамжийн мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
26		Дулаан хангамжийн мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
27		Автоматик, электроникийн мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
28	Инженер /зураг зүйч/	М	2,392,600	2,871,120	
29	Технологийн бодлогын хэлтэс	Хэлтсийн дарга	У	4,000,000	4,032,000
30		Ерөнхий технологич	А-М	2,487,800	2,985,360
31		Чанарын инженер	ИТА	2,392,600	2,871,120
32	Түүхий эдийн хольц тохируулгын алба	Инженер /түлш түүхий эдийн балансжуулалт хариуцсан/	ИТА	2,392,600	2,871,120
33		Талбайн инженер	ИТА	2,392,600	2,871,120
34	Шуурхай удирдлагын төв	Ахлах мэргэжилтэн /шуурхай удирдлага/	А-М	2,487,800	2,985,360
35		Инженер /шуурхай удирдлага/	ИТА	2,289,000	2,746,800
36	Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс	Хэлтсийн дарга	У	4,000,000	4,032,000
37		Ахлах эдийн засагч	А-М	2,487,800	2,985,360
38		Үйлдвэрлэлийн эдийн засагч	М	2,392,600	2,871,120
39		Хөдөлмөрийн эдийн засагч	М	2,392,600	2,871,120
40		Төсөвчин	М	2,392,600	2,871,120
41	Санхүү, тайлан бүртгэлийн хэлтэс	Ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, тайлан, бүртгэлийн хэлтсийн дарга	У	4,000,000	4,032,000
42		Ахлах нягтлан бодогч	А-М	2,487,800	2,985,360
43		Цалин, мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч	М	2,487,800	2,985,360
44		Өглөг, үндсэн хөрөнгийн нягтлан бодогч	М	2,392,600	2,871,120
45		Авлага, борлуулалтын нягтлан бодогч	М	2,392,600	2,871,120
46		Материалын нягтлан бодогч	М	2,392,600	2,871,120
47		Касс, аж ахуй, хөдөлмөр хамгааллын нярав	ТА	1,727,600	2,073,120
48	Худалдан авах ажиллагааны хэлтэс	Хэлтсийн дарга	У	4,000,000	4,032,000
49		Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн	А-М	2,487,800	2,985,360
50		Механик сэлбэг хариуцсан мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
51		Түлш, түүхий эд хариуцсан мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
52		Хангамжийн мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
53		Цахилгаан сэлбэг хариуцсан мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
54		Механик сэлбэгийн нярав	ТА	1,727,600	2,073,120

ЦЕМЕНТ ШОХОЙ ТӨХК
 9022040181 268984 ЦДКР0665

55		Цахилгаан сэлбэгийн нярав	ТА	1,727,600	2,073,120
56		Түлш, түүхий эдийн нярав	ТА	1,727,600	2,073,120
57		Ачигч	YA	1,120,000	1,344,000
58	Дотоод аудитын хэлтэс	Хэлтсийн дарга	У	4,000,000	4,032,000
59		Хяналтын мэргэжилтэн	М	2,487,800	2,985,360
60		Хэлтсийн дарга	У	4,000,000	4,032,000
61	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй байгаль орчны хэлтэс	Ахлах инженер /ХАБЭА/	А-М	2,487,800	2,985,360
62		Инженер /ХАБ хяналтын/	М	2,392,600	2,871,120
63		Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэргэжилтэн	М	2,392,600	2,871,120
64		Инженер /байгаль орчны/	ИТА	2,289,000	2,746,800
